# ХЭНТИЙ АЙМГИЙН
# ДАДАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
# ТӨВИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2026 оны 02 сарын 16 өдөр Дугаар А/11. Баян-Овоо

Хариуцлагатай жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн "Журам батлах тухай" А/36 дугаар тушаал, 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай" 01 албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтээр тэмдэглэх баярын өдөр болох цагаан сар 2026 оны 2 дугаар сарын 17-ний өдрөөс 2026 оны 2 дугаар сарын 22-ны өдрийг дуустал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах хариуцлагатай жижүүр хийх албан хаагчдын хуваарийг нэгдүгээр, хариуцлагатай жижүүрийн ажиллах нийтлэг журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Томилогдсон хариуцлагатай жижүүрүүд эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүртэй холбогдон мэдээгээ цаг хугацаанд нь тогтмол өгөх. /осол гэмтэл, хордлого, зөрчил/

3.Бүх эмч мэргэжилтэн, ажилчид гар утсаа байнга нээлттэй байлгахыг үүрэг болгосугай.

4.0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, төрөлт, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд осол гэмтэл, яаралтай тусламжийн дуудлагад цаг алдалгүй хөнгөн шуурхай үйлчлэхийг эх баригч хариуцсан ажилтан (Б.Пүрэвдорж), дуудлагын эмч нарт тус тус үүрэг болгосугай.

5.Яаралтай тусламжийн болон, тасгийн эм тарианы бэлэн байдалд хяналт тавьж ажиллахыг эм баригч (Д.Хэрлэн)-д даалгасугай.

6.Алсын болон ойрын дуудлагад явах түргэн тусламжийн машины бүрэн бүтэн байдлыг хангаж, шатахууныг хангалттай хэмжээнд нөөцлөхийг жолооч (Б.Хэрлэн)-д даалгасугай.

7.Байгууллагын эргүүлд гарсан албан хаагчдыг удирдлагаар хангаж ажиллахыг дүн бүртгэгч (Ш.Болортуяа)-д даалгасугай.

8.Барилга, байгууламжийн ус, дулааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг шалгаж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангахыг жолооч (Б.Хэрлэн)-д даалгасугай.

ДАРГА Б.ОДМАА

Эрүүл мэндийн төвийн Даргийн
2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
А/11 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

| № | Овог, нэр | Албан тушаал | Утасны дугаар | Овог, нэр | Албан тушаал | Ажиллах өдөр | Танилцсан |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Х.Минжээ | Их эмч | 98380577 | М.Энхзул | Ээлжийн сувилагч | 2026.02.17 | |
| 2 | Б.Пүрэвдорж | Эх баригч | 95925556 | С.Номинцэцэг | Ээлжийн сувилагч | 2026.02.18 | |
| 3 | Б.Одмаа | ЭМТ-ийн дарга | 98146121 | П.Ариунтунгалаг | Ээлжийн сувилагч | 2026.02.19 | Б.Одмаа |
| 4 | Х.Минжээ | Их эмч | 98380577 | М.Энхзул | Ээлжийн сувилагч | 2026.02.20 | |
| 5 | Б.Пүрэвдорж | Эх баригч | 95925556 | С.Номинцэцэг | Ээлжийн сувилагч | 2026.02.21 | |
| 6 | Б.Одмаа | ЭМТ-ийн дарга | 98146121 | П.Ариунтунгалаг | Ээлжийн сувилагч | 2026.02.22 | Б.Одмаа |